

## “МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ОЮУТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь оюутны суралцах үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн зарчим, хэм хэмжээг тогтоож, хэвшүүлэн сахиулах, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, таслан зогсоох, ёс зүйн зөрчлийн талаарх санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Оюутан нь шинжлэх ухааны мэдлэг, мэргэжлийн ур чадвартай, хууль шударга ёсыг дээдэлдэг, хүнлэг иргэн болохын төлөө хичээнгүйлэн суралцана.
- 1.3. Оюутны ёс зүй нь сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй явуулах үндсэн нөхцөл бөгөөд оюутнаас ёс зүйн хэм хэмжээг заавал сахиж мөрдөхийг шаардана.
- 1.4. Энэхүү оюутны ёс зүйн дүрэм нь тус сургуулийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, оюутны дүрмийн салшгүй хэсэг байх болно.
- 1.5. Оюутны ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

### Хоёр. Дүрмийн нэр томъёо

2.1. Дүрэмд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар хэрэглэнэ. Үүнд:

2.1.1. “Оюутан” гэж “Монгол Коосэн” Технологийн коллежид /цаашид сургууль гэх/ элсэн орж, суралцаж буй суралцагч;

2.1.2. “Оюутны ёс зүйн зарчим” гэж суралцах хугацаанд баримтлах чиг баримжаа;

2.1.3. “Оюутны ёс зүйн хэм хэмжээ” гэж оюутны суралцах хугацаанд мөрдөхөөр тогтоосон шаардлагын цогц;

2.1.4. “Оюутны ёс зүйн зөрчил” гэж энэхүү дүрмээр тогтоосон оюутны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл;

2.1.5. “Ёс зүйн зөвлөл” гэж багш, ажилтан, оюутны ёс зүйн асуудлаар үйл ажиллагаа зохион байгуулж, зөвлөмж, дүгнэлт гаргах эрх үүрэг бүхий сургуулийн орон тооны бус нэгж;

2.1.6. “Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан санал гомдлыг холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэх явц.

## Гурав. Оюутны дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ

3.1. Оюутан нь суралцах хугацаандаа эрдэм мэдлэг эзэмших зорилгыг урьтал болгож, ямагт өөрийгөө хөгжүүлж, сурлагадаа ахиц дэвшил гаргаж байх нь суралцагчийн эрх ашигт бүрэн нийцэх төдийгүй улс орны хөгжил цэцэглэлтэд оруулах хувь нэмэр мөн.

3.2. Оюутан нь суралцах явцдаа хууль, шударга ёсыг дээдлэн, хүнлэг энэрэнгүй байж, зөв боловсон харилцааг эрхэмлэнэ.

3.3. Оюутан нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ёс зүйн дараах хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

3.3.1. Сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлийг судлах ба хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмшинэ;

3.3.2. Бие даан бүтээлч хандлагаар суралцах чадвар эзэмшиж, сурах эрэл хайгуул хийнэ;

3.3.3. Хичээлийн хөтөлбөр, хуваарь, цаг баримтална;

3.3.4. Хичээлийн даалгавар, бие даалт, дадлагын тайлан, төгсөлтийн ажлыг цаг хугацаанд нь гүйцэтгэж, хамгаална;

3.3.5. Сургуулийн болон олон нийтийн өмч хөрөнгө, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлага, анги танхимын эд хогшил, ширээ сандлыг ариг гамтай эдэлж ашиглана;

3.3.6. Оюутан нь багш шавийн барилдлагыг хүндэтгэнэ;

3.3.7. Бусдыг нас, хүйс, яс үндэс, шашин шүтлэг, оюуны чадавхи, үзэл бодол, нутаг ус, танил тал, гадаад үзэмж, эд хөрөнгө, нийгмийн гарал, гэр бүлийн байдал, төгссөн сургууль, эрүүл мэндийн онцлог шинжээр ялгаварлан гадуурхахгүй байх;

3.3.8. Компьютер ашиглан мэдээ, мэдээлэл авах чадвартай байна;

3.3.9. Цахим орчинд бусадтай зөв боловсон, хүндэтгэлтэй харьцаж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх;

3.3.10. Ахмад настан, эрдэмтэн багш, ажилтан, ажилчид, сургуулийн оюутнууд, найз нөхөд, зочид хэн бүхэнтэй зөв боловсон харьцаж, мэндэлдэг байх;

3.3.11. Цэвэрч нямбай, зөв боловсон хувцаслах;

3.3.12. Олон нийтийн газар, гудамж талбайд бусадтай зөв боловсон харьцаж, биеэ зөв авч явах;

3.3.13. Аливаа ажилд чин сэтгэлээсээ хандаж, хуурч мэхлэх, худал ярих зэрэг шударга бус зүйлтэй үл эвлэрнэ;

3.3.14. Хүнлэг, энэрэнгүй, соёлтой байна;

3.3.15. Хамт суралцагч болон багшийн зүгээс сургалттай холбоотой ба сургалтын бус асуудлаарх бодит шүүмжлэл, санал бодлыг хүндэтгэлтэй хүлээн авч, аливаа маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдэх;

3.3.16. Сургууль, хамт олны нэр хүндийг өндөрт өргөж, үйл ажиллагаанд нь санаатай болон санамсаргүйгээр саад учруулахаас зайлсхийх;

3.3.17. “Монгол Коосэн” Технологийн коллежийн оюутны дүрэм болон энэхүү оюутны ёс зүйн дүрэмтэй танилцаж, дагаж мөрдөнө.

3.4. Хориглосон хэм хэмжээ буюу дараах үйлдэл, эс үйлдлийг ёс зүйн зөрчил гэж үзнэ. Үүнд:

3.4.1. “Монгол Коосэн” Технологийн коллежийн эрхэм зорилго, нэр хүндийг унагах аливаа үл хүндэтгэсэн үйлдэл үзүүлэх;

3.4.2. Сургуулийн багш, ажилтан, суралцагсдын хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх;

3.4.3. Сургуулийн эд хөрөнгийг хувийн зорилгод ашиглах;

3.4.4. Хамт суралцагсад болон бусад хүмүүсийг үндэс угсаа, нас, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, оюуны чадавхи, үзэл бодол, бэлгийн чиг хандлага, эрүүл мэндийн онцлог шинжээр ялгаварлан гадуурхах, тэгш бус хандах, анги, курсийн ялгаа гаргах;

3.4.5. Сургууль болон олон нийтийн газар бусадтай зүй бус харьцах, архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, гэм хор учруулах;

3.4.6. Хичээлийн цагаар бусдын сурах үйл ажиллагаанд саад учруулах, бусдын тавьсан шаардлагыг үл ойшоож хичээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;

3.4.7. Хичээлийн цагаар хичээлд холбогдолгүй зүйл хийх, утсаар ярих, мессэж бичих, тоглох, дуу хөгжим сонсох зэргээр цахим хэрэгслийг хичээлийн бус зориулалтаар ашиглах;

3.4.8. Сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн сурах бичиг, гарын авлагыг зүй зохисгүй ашиглах, гэмтээх, устгах, дахин ашиглах боломжгүй болгох;

3.4.9. Багш, ажилтан, оюутан нөхдөө үл хүндэтгэх харьцах, доромжлох, нэр хүндийг нь гутаах, дарамтлан сүрдүүлэх, эд хөрөнгийг нь эвдлэх, гэмтээх;

3.4.10. Багш, ажиллагсад болон бусад эрх бүхий хүмүүст өөрт ашигтай шийдвэр гаргуулахаар хээл хахууль өгөх, өгөхийг завдах;

3.4.11. Бусдыг айлган сүрдүүлэх, эрхшээлдээ оруулах, дарамтлах, нэр хүндийг нь гутаах, биед нь халдах, гэмтэл учруулах зодож гэмтээх, элдэв татаас, мөнгө нэхэж авах, дээрэмдэх;

3.4.12. Садар самууныг сурталчилах, түүнд бусдыг уруу татах, бусдад бэлгийн дарамт үзүүлэх;

3.4.13. Оюутан өөрийн хувийн үзэл бодлоо бусдад тулгах, шашны сурталчилгаа хийх;

3.4.14. Сургуулийн газар хөзөр, компьютерийн тоглоомыг мөрийтэй тоглох;

3.4.15. Ёс зүйн зөрчил гарсан болон гаргасныг мэдэж байж санаатай нуун дарагдуулах;

3.4.16. Сургуулийн орчинд ил задгай, зохисгүй хувцаслах;

- 3.4.17. Өвчтэй, ханиад томуу болон халдварт өвчин туссан үед хичээлд явахдаа бусдыг үл хүндэтгэн амны хаалт хэрэглэхгүй явах;
- 3.4.18. Хичээл таслах, хичээлээс хоцрох, хичээл дундуур зөвшөөрөлгүй гарч явах;
- 3.4.19. Сургуулийн анги, танхим, албан тасалгаа, дотуур байранд зөвшөөрөлгүй нэвтрэх, дотор нь байрлах;
- 3.4.20. Сургуулийн орчинд хэт чанга дуу авиа гаргах, орилох, исгэрэх, чанга инээлдэх, хөгжим дуугаргах;
- 3.4.21. Сургуулийн орчинд элдэв хог, шүлс, нус цэр, бохь, тамхины иш хаях, цонх, тагтнаас элдэв юм шидэх, тамхи татах;
- 3.4.22. Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалтын ажилчдыг үл ойшоох, хөдөлмөрийг нь үл хүндлэх;
- 3.4.23. Сургуулийн зохих албан тушаалтан зөвшөөрсөн, сургуулийн дүрэм, журамд зааснаас бусад тохиолдолд халуун, хүйтэн зэвсэг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис зэрэг аюултай зэвсэг, хэрэглэл ашиглах, хадгалах;
- 3.4.24. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, үйлдвэрлэх, түгээх, борлуулах, хадгалах;
- 3.4.25. Шалгалтын ажлыг гүйцэтгэх явцад бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл авах, шалгалтад зөвшөөрөгдөөгүй материал авч орох, ашиглах, гар утас, цахим хэрэгсэл хэрэглэх;
- 3.4.26. Бусдын өмнөөс шалгалт өгөх, бусдыг өөрийнхөө өмнөөс шалгалтад оруулах;
- 3.4.27. Бие даан гүйцэтгэхээр заасан лабораторийн ажил, дадлага, судалгааны ажил, хичээлийн бие даалтыг бусдаар хийлгэх, бусдын хийсэн зүйлийг хуулбарлах;
- 3.4.28. Хичээлийн даалгавар, бие даалтын ажил гүйцэтгэхдээ бусдын хийсэн ажил, дэвшүүлсэн санааг өөрийн болгож хууран мэхлэх;
- 3.4.29. Багшийн өгсөн дүн, оноог засах;
- 3.4.30. Дүнгийн хуудас, оюутны үнэмлэх, биеийн байцаалт, хөнгөлөлтийн хуудас, тодорхойлолт зэрэг албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, засвар оруулах, өөрчлөх, зүй бусаар бусдад дамжуулах, ашиглуулах, устгах;
- 3.4.31. Суралцах явцад бусадтай шударга бусаар өрсөлдөж, өөртөө давуу байдал бий болгох;
- 3.4.32. Бусдыг хилсээр буруутгах, мэдээллийг гуйвуулах, нуун дарагдуулах, худал мэдээллэх, хутган үймүүлэх, бусдыг гүтгэх, худал мэдүүлэх зэрэг ноцтой үйлдэл гаргах.

#### Дөрөв. Ёс зүйн зөрчил гаргагчдад хүлээлгэх хариуцлага

- 4.1. “Монгол Коосэн” Технологийн коллежийн нийт багш, ажилтан, оюутан бүр ёс зүйн зөрчил гарсан даруйд нь таслан зогсоох, зүй ёсны шаардлага тавих, Зөвлөлд хандан ёс зүйн зохисгүй үйлдлийн талаар мэдээллэх үүрэгтэй.

- 4.2. Ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлыг Ёс зүйн зөвлөл хянан шийдвэрлэх бөгөөд зөрчил гаргасан оюутанд зөрчлийн хэм хэмжээ, нөхцөл байдал, нийтэд илэрхий байдлыг харгалзан сургуулийн захирал тушаал гаргаж, дараах сахилгын шийтгэлийг ногдуулна. Үүнд:
- 4.2.1. Амаар болон бичгээр сануулах
  - 4.2.2. Улируулан суралцуулах
  - 4.2.3. Оюутныг сургуулиас чөлөөлөх
- 4.3. Сануулах сахилгын шийтгэлийг анх удаа зөрчил гаргасан буюу зөрчлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан оюутанд ногдуулж, оюутны буруугаас сургуульд эд хөрөнгийн хохирол учирсан бол хохирлыг нөхөн төлүүлэх, ёс зүйн зөрчлийг удаа дараа гаргасан, хуулийн байгууллагаар зөрчил, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол сургуулиас хасах хүртэл сахилгын шийтгэл ногдуулна.
- 4.4. Сургуулиас хасах сахилгын шийтгэл хүлээсэн оюутны хичээлд суусан хугацааны сургалтын төлбөрийг суутган тооцох бөгөөд энэхүү дүрэмд заасан ёс зүйн зөрчил гэж үзсэн үйлдлүүдийг мэдээгүй байсан нь хариуцлага хүлээлгэхгүй байх үндэслэл болохгүй.
- 4.5. Сургуулийн хөдөлмөрийн дотоод журам, оюутны ёс зүйн дүрмийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй зөрчлийг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

-00o00-